



**Opening Extractives** Unlocking the benefits of ownership data

# Эцсийн өмчлөгчийн ил тод байдал




## ОЛБОРЛОХ САЛБАРТ АВИЛГА ӨНДӨР

Хил дамнан авилгын эсрэг хууль (FCPA)-ын дагуу арга хэмжээ авсан хэргүүдийн 20 гаруй хувь нь уул уурхай, газрын тос, байгалийн хийн салбарт хамаарч байв.

## НУУЦЛАГ КОМПАНИУД АВИЛГЫН ЭРСДЭЛТЭЙ

Авилгын хэргүүдийн 70% далд өмчлөл бүхий компаниудаар дамждаг.

## Монгол Улсын хувьд ч цөөнгүй жишээг дурьдаж болно.



Салбарт итгэх нийгмийн итгэлийг бүрдүүлдэг

Авилга, мөнгө угаах, татвараас зугатах явдлыг хязгаарладаг

Засаглалын чанарыг сайжруулснаар эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлдэг

Олон улсын хөрөнгө оруулагид болон санхүүгийн байгууллагуудын зүгээс улс орон, компаниудад энэ чиглэлээр тавих шаардлага улам өндөрсөж байна

## Амлалт



Монгол Улс 2007 оноос олон улсын Олборлох Үйлдвэрлэлийн Ил тод Байдлын Санаачилгад (ОУИТБС) нэгдэн орж түүний стандарт шаардлагуудыг хэрэгжүүлэх амлалт үүрэг хүлээсэн.

## Open Ownership



2021 оны 5 дугаар сард ОУИТБС болон Нээлттэй Өмчлөл байгууллагууд хамтран хэрэгжүүлж буй "Олборлох салбарыг нээх нь" хөтөлбөрт нэгдсэн.



2013 онд нэгдэн орж өнөөг хүртэл хамтан ажиллаж буй Нээлттэй Засаглалын Түншлэл олон улсын байгууллагын гишүүний хувьд 2021-2023 онд хэрэгжүүлэх Үндэсний хөтөлбөртөө олборлох салбарын болон эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хуульчлахаар төлөвлөсөн.



Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /FATF/-ын өмнө мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хүлээсэн үүрэгт эцсийн өмчлөгчийн ил тод байдлын асуудал багтдаг.

# Эрх зүйн орчин

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 2018 оны нэмэлт өөрчлөлтөөр эцсийн өмчлөгчийн тодорхойлолтыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилсэн.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 2019 оны нэмэлт өөрчлөлтөөр УБЕГ аж ахуйн нэгжүүдийн эцсийн өмчлөгчийн бүртгэлийг нэгтгэн хийхээр заасан.

2022 оноос хэрэгжиж буй Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг нийтэд байнга, ил тод байлгахар хуульчилсан. Уг мэдээлэл нь Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд агуулагдана.

Мөн Татварын ерөнхий хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Банкны тухай хуульд эцсийн өмчлөгчийн мэдээллийн асуудал туссан.

Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн сайд, Үндэсний Статистикийн Хорооны дарга нарын 2022 оны хамтарсан тушаалаар батлагдсан ОУИТБС-ын тайлан гаргах маягтад эцсийн өмчлөгчийн мэдээллийг заавал тайлагнахаар тусгасан.

2018


2019

2022

2022

2022

## Оролцогч талууд



**Opening Extractives** Unlocking the benefits of ownership data